

**“ТӨРӨӨС БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫГ
ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сумьяабазар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг 2014-2024 он хүртэл 10 жилийн хугацаанд иргэн бүрт олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай, хүртээмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлэх талаар мөн боловсролын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй, нээлттэй, техник технологийн дэвшилд суурилсан, залгамж холбоотой байх зарчмыг баримтлан хүрэх үр дүн, түвшинг шинэчлэн бодлогын баримт бичгийг боловсруулжээ.

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн баталснаар Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсролын чанарын баталгааг хангаж, олон улсад өрсөлдөх чадвар бүхий боловсролын үйлчилгээний эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзжээ.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Амаржаргал бодлогыг ямар судалгаа, юунд тулгуурлаж боловсруулсан нь тодорхойгүй, нэр томъёоны тодорхойлолт байхгүй, бие бялдрын хүмүүжлийн асуудлыг орхигдуулсан, боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдлыг ямар шалгуураар хэмжих нь тодорхой бус байгааг цаашид анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан бодлогын баримт бичигт боловсролын тогтолцооны өнөөгийн гажуудлыг хэрхэн засаж залруулах талаар тусгах, бодлого шинэчлэгдсэнээр хүрэх үр дүн, түвшинг тодорхой тусгах шаардлагатай, мөн дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын хоорондын уялдаа холбоог цаашид бодлогоор дэмжих нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь ерөнхий боловсрол болон дээд боловсролын салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар бодлогод тодорхой тусгах, дээд боловсролын чанарыг сайжруулах, ёс суртахуунтай, эрэлт хэрэгцээнд нийцсэн чадварлаг багшлах боловсон хүчин бэлтгэх асуудалд онцгойлон анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг эрүүл аюулгүй орчинд 2-4 насны хүүхдийг асарч хамгаалах хүүхэд харах үйлчилгээг шинээр бий болгож бодлогоор дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Е.Отгонбаяр бодлого ойлгомжтой, хэрэгжих үе шат, хүрэх үр дүн, санхүүжилт нь тодорхой байх хэрэгтэй, бодлогын баримт бичгийн зарим заалтууд хоёрдмол утгатай байгааг анхаарах, гэр бүл, хүмүүжил гэсэн бүлэг шинээр нэмэх, багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг

тодорхой зааж өгөх, Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан дээд боловсролтой иргэдийг хөдөлмөрийн зах зээлд ажлын байраар хангах асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах, дээд боловсролын талаар баримтлах бодлого, ерөнхий боловсролын талаар баримтлах бодлого гэж тус тусад нь бодлогыг нь тодорхойлох, Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар бага, дунд, дээд боловсролын салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга зам, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, үнэлгээг тодорхой зааж өгөх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлын талаарх Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ